

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 3 дугаар сарын

Улаанбаатар хот

“ 29 ”-ний өдөр

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Гадаад харилцааны яам /ГХЯ/-ны 2017 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг боловсруулж яамны удирдлагад танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.

Тайланд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд гадаад бодлого, гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар тусгагдсан зорилт, арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн явц, байдлыг гаргаж, биелэлтийн хувь, үнэлгээг тусгав.

Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2017 оны жилийн эцсийн биелэлтийг гаргаж Засгийн газрын unelgee.gov.mn нэгдсэн цахим хуудсанд байрлуулсан дүнг тайланд тусгасан болно.

Дээр дурдсан журмын 9.1.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт /Хавсралт-1/, Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан /Хавсралт-2/, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ /Хавсралт-3/, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт /Хавсралт-4/, Хэрэглэгчийн үнэлгээний тайлан /Хавсралт-5/, мөн журмын 7 дугаар хавсралтын дагуу ГХЯ-ны жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг /Хавсралт-6/ тус тус гарган хавсаргав.

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралтын дагуу Гадаад харилцааны салбарт холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн явцыг 2017 оны байдлаар нэгтгэн журамд заасан хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлсэн.

2017 оны байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар зэрэг хяналтад авсан нийт 10 төрлийн **178** хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн Гадаад харилцааны яамны чиг үүрэгт хамаарах **245** зүйл, заалтыг хяналтад авсан байна.

2017 онд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 245 зүйл, заалтаас 151 нь 100 хувийн, 88 нь 70 хувийн, 3 нь 30 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжсэн буюу хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 2 байна.

Хэрэгжилтийн дундаж үзүүлэлт нь **88.2** хувийн гүйцэтгэлтэй байна.

Гадаад харилцааны яамны чиг үүрэгт хамаарах эрх зүйн актын хэрэгжилтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар хүснэгтэд харуулав.

№	Эрх зүйн актын нэр	Шийдвэр тоо	Зүйл, заалтын тоо	Биелэлтийн хувь				Дундаж хувь
				100	70	30	хугацаа эхлээгүй	
1	МУ-ын хууль	2	2	2				100
2	Улсын Их хурлын тогтоол	1	2	1	1		-	85
3	УИХ-ын байнгын хорооны тогтоол	5	9	6	3		-	90
4	Ерөнхийлөгчийн зарлиг	4	5	4	1			94
5	ҮАБЗ-ийн зөвлөмж	2	2	2	-			100
6	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	49	49	23	25		1	84.38
7	Засгийн газрын тогтоол	27	31	24	6		1	94
8	Ерөнхий сайдын захирамж	8	8	5	3			88.75
9	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	79	125	84	38	3		89.20
10	Засгийн газрын албан даалгавар	1	12		11			70
	Нийт	178	245	151	88	3	2	88.2

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/-т 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 13/259 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд гадаад харилцааны чиглэлээр тусгагдсан тус яам болон бусад яамтай хамтран хэрэгжүүлэх нийт 35 зорилтын 110 ажил, арга хэмжээнээс үндсэн хэрэгжүүлэгчээр 64, хамтран хэрэгжүүлэгчээр 46 ажил, арга хэмжээ, хариуцан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 46 ажил, арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа ГХЯ-ны гүйцэтгэсэн ажлыг тайлагнаж, хэрэгжилтэд үнэлгээ тавихгүй байхаар заасан тул үндсэн хэрэгжилтийг хариуцагч бусад байгууллага тайлагнах болно.

Түүнчлэн жилийн эцсийн үнэлгээг гаргахдаа төлөвлөгөөнд заасан 2017 оны хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлттэй харьцуулан энэ оны хэрэгжилтийн дүнг тооцов.

ГХЯ-ны дангаараа хэрэгжүүлэх 64 ажил, арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг хувиар үзүүлбэл:

Д/д	Хөтөлбөрийн заалтын хэрэгжилтийн хувиар				
	100	90	80	70	Үнэлэх боломжгүй
1.	5.6.11.2	2.11.2	5.6.1.2	5.6.1.9	5.6.3.7
2.	5.6.11.3	4.2.5.4	5.6.8.3	5.6.6.3	5.6.9.5
3.	5.2.6.4	5.6.1.3		5.6.7.2	5.6.12.1
4.	5.6.1.1	5.6.1.4		5.6.8.1	5.6.12.4
5.	5.6.1.7	5.6.4.1		5.2.6.1	4.4.4.5
6.	5.6.1.10	5.6.8.2		5.2.6.2	5.6.2.3
7.	5.6.1.11	5.6.12.2		5.2.6.3	5.6.6.5
8.	5.6.7.4	5.6.7.5		5.6.1.12	5.6.6.6
9.	5.6.2.1	5.6.9.4		5.6.3.4	
10.	5.6.2.2	5.6.10.2		5.6.7.3	
11.	5.6.6.7	5.6.11.1		5.6.9.1	
12.	5.6.2.4	5.6.12.3		5.6.9.3	
13.	5.6.3.1			2.11.1	
14.	5.6.3.2				
15.	5.6.3.3				
16.	5.6.3.6				
17.	5.6.3.5				
18.	5.6.4.2				
19.	5.6.4.3				
20.	5.6.5.1				
21.	5.6.6.1				
22.	5.6.6.2				
23.	5.6.6.4				

24.	5.6.6.10					
25.	5.6.8.4					
26.	5.6.9.2					
27.	5.6.10.4					
28.	5.6.10.1					
29.	5.6.13.1					
30.	5.6.10.5					
Нийт	30	12	2	13	8	64

№	Биелэлтийн дүн хувиар	Төлөвлөсөн ажлын тоо ширхэг /Үнэлгээ өгөх 64 ажил арга хэмжээ/	
		2017.06.25	2017.12.31
1.	100	14	30
2.	90	5	12
3.	80	13	2
4.	70	13	13
5.	60	4	0
6.	50	7	0
7.	40	3	0
8.	30	3	0
9.	Үүнээс хугацаа хойшлогдсон, гадны хүчин зүйлээс шалтгаалан үнэлгээ өгөх боломжгүй заалт	2	8
Дундаж хэрэгжилт		73.2%	91.96%

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2017 жилийн эцсийн биелэлт дунджаар **91.96** хувийн гүйцэтгэлтэй байна.

Дээр дурдсан журамд заасны дагуу зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй, мөн зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэх шаардлагатай буюу 59 хувиас доош хэрэгжилттэй байгаа ажил, арга хэмжээ байхгүй байна.

Тодорхой үр дүнд хүрсэн ч хэрэгжилт бүрэн биелсэн буюу 90-100 хувиар үнэлэх боломжгүй хэмээн дүгнэж байгаа 15 ажил, арга хэмжээ байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилтийн тайланг ЗГХЭГ-т 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 13/412 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

1.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд ГХЯ-ны үйл ажиллагаанд хамаарах 5 зорилтын 8 ажил, арга хэмжээ тусгагдсан байна.

ГХЯ-ны үйл ажиллагаанд хамаарах 8 ажил, арга хэмжээнд үнэлгээ өгөх 11 шалгуур үзүүлэлттэйгээс 100 хувийн биелэлтэй 7, 90 хувийн биелэлтэй 2, 80 хувийн биелэлтэй 1, 70 хувийн биелэлтэй 1 ажил, арга хэмжээ, биелэлтийн дундаж нь 93.6 хувьтай байна.

д/д	Зорилт, арга хэмжээ	Биелэлтийн хувь
Нэг. Зорилт 4 Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.		
4.5	Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах;	100
Хоёр. Зорилт 7. Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн зам, тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.		
7.1	Дамжин өнгөрөх тээврийн эрх зүйн орчныг сайжруулж, тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх	100
Гурав. Зорилт 11. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.		
11.8	“Монгол судлал”-ыг бодлогоор дэмжиж, тогтвортой хөгжих нөхцөлийг бүрдүүлэх;	100
Дөрөв. Зорилт 12. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.		
12.2	Гадаадад эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлж байгаа монгол эрдэмтдийг дотоодын судалгааны ажилд оролцуулах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх;	90
Тав. Зорилт 16. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулж, хилийн чанадад амьдарч буй монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулан, хөрш орнуудад хийх худалдааг өргөжүүлэх бодлого баримтална.		
16.1	Монгол-ОХУ-БНХАУ-ын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Хөрөнгө оруулалтын төв байгуулах чиглэлээр ажиллах;	100
16.2	Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх;	95
16.3	Хөрш орнуудад хийх худалдааг өргөжүүлэх бодлого баримтлах, гадаад худалдааг хөгжүүлэх зорилгоор чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх;	75
16.4	Хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах;	100
Дундаж хувь		93.6%

Тус яамнаас хэрэгжүүлэх дээрх зорилтуудад тусгасан ажил, арга хэмжээнүүдээс 3 нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, үүнээс 2 /4.5, 11.8/ нь бусад төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусгагдаж, зарцуулалтын тайланг тухайн байгууллагууд, харин тус яам дангаар хэрэгжүүлэх, 5 дугаар зорилтын 16.4-т туссан “Хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах” ажил, арга хэмжээний хүрээнд төсөвлөгдсөн 990.0 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Үндсэн чиглэлийн биелэлтийг 2017 оны жилийн эцсийн байдлаар гаргаж Сангийн яаманд 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 13/413 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

1.4.Гадаад харилцааны яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 55 дугаар тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор баталсан “Яамдын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн Гадаад харилцааны яамны нийт 12 үзүүлэлт, 16 заалтад 2017 оны байдлаар үнэлгээ хийхэд бүгд 100 хувийн үнэлгээтэй гарсан. /Хавсралт-1/

Хоёр. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

2.1. Гадаад харилцааны яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Гадаад харилцааны яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 173 зорилт арга хэмжээний биелэлтийг үзэхэд 140 ажил 100 хувь , 6 ажил 90 хувь, 10 ажил 80 хувь, 1 ажил 60 хувийн биелэлттэй, хугацаа хойшлогдсон, гадны хүчин зүйлээс шалтгаалан үнэлгээ өгөх боломжгүй 16 заалт байна.

Биелэлтийн хувийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Биелэлтийн дүн хувиар	Төлөвлөсөн ажлын тоо ширхэг, Төлөвлөгөөний заалтын дугаар		
		2017.12.13	2017.10.03	2017.08.23
1.	100	140	63	49
2.	90	6	31	28
3.	80	10	29	32
4.	70	0	20	22
5.	60	1	17	31
6.	50	0	7	10
7.	40	0	19	19
8.	30	0	4	5
9.	Үүнээс хугацаа хойшлогдсон, гадны хүчин зүйлээс шалтгаалан үнэлгээ өгөх боломжгүй заалт	16	16	10
Дундаж хэрэгжилт /хувиар/		98	79.2	75.4

Яамны үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөний биелэлт дунджаар 98 хувьтай байна.

ГХЯ-ны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ЗГХЭГ-т 2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 13/411 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

2.2. Гадаад харилцааны яамны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт:

ГХЯ-ны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын 2017 оны жилийн төлөвлөгөөнд 4 зорилт тусгагдсан бөгөөд биелэлтийг дээр дурдсан журмын 10 дугаар хавсралтад дурдсан шалгуур үзүүлэлтээр гаргахад 8 үзүүлэлт 100 хувь, 1 үзүүлэлт 98.5 хувь, 1 үзүүлэлт “үнэлэх боломжгүй” гэсэн үнэлгээтэй, нийт үнэлгээний дундаж хувь 89.9 хувьтай байна. /Хавсралт-5/

Гурав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

3.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Гадаад харилцааны яамны албан ёсны цахим хуудас [/www.mfa.gov.mn/](http://www.mfa.gov.mn)-д 2017 оны турш нийт 656 мэдээ, мэдээлэл тавигдсан байна. Үүнээс үндсэн үйл явдал цэсэнд 433, ДТГ-аас ирсэн мэдээ цэсэнд 190, зарлал цэсэнд 31, ярилцлага цэсэнд 1, видео цэсэнд 1 ярилцлагыг тус тус байршуулжээ.

Түүнчлэн дипломат харилцаатай орнуудын мэдээлэл, гадаад харилцааны яамны бүтэцтэй холбоотой мэдээллийг 2017 онд шинэчлэн байршуулав.

Гадаадад ажиллаж амьдарч буй иргэдтэй холбоотой буюу консулын харилцаатай холбоотой мэдээлэл яамны цахим хуудасны консулын мэдээлэл цэсээр дамжин consul.mn цахим хуудсанд байршиж мэдээг байнга шинэчлэн баяжуулж, гадаад улсад амьдарч буй иргэдэд шаардлагатай мэдээ, мэдээллийг байршуулж ажиллав.

Ил тод байдлын 2017 оны үнэлгээ дунджаар 96.3 хувийн хэрэгжилттэй байна.

Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайланг хавсаргав. /Хавсралт-2/

3.2. Шилэн дансны хөтлөлийн үнэлгээ

ГХЯ хилийн чанадад үйл ажиллагаа явуулж буй 42 Дипломат төлөөлөгчийн газар /ДТГ/-ын шилэн данс хөтлөлтөд “Шилэн дансны тухай” хуулийн 8.2 заалт, ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичиг”-ийн хамрах хүрээний 3.2.3.5-д заасны дагуу хуулийн хэрэгжилт болон мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, цаг тухайд нь байршуулсан эсэхэд долоо хоног бүр хяналт тавьж, улирал бүр үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэн эрсдэлийн удирдлагаар ханган ажиллав.

ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмын дагуу мэдээллийг байршуулсан байдлыг 2017 оны жилийн байдлаар дүгнэж үзэхэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт **87.7** хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Тайлант хугацаанд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт нь “А” үнэлгээтэй 32 ДТГ, “В” үнэлгээтэй 1, “С” үнэлгээтэй 3, “D” үнэлгээтэй 6 ДТГ байна. /Хавсралт-3/

3.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

Авилгатай тэмцэх газар нь “Авилгын эсрэг хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авилгын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авилгын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний 2016 оны тайланд ГХЯ нь нийт 60 байгууллагаас 13 дугаар байрт 73.5 оноогоор, гадаад шударга байдлын үнэлгээгээр 3 дугаар байрт 63.3 оноогоор, дотоод шударга байдлын үнэлгээгээр 3 дугаар байрт 86.6 оноогоор орсон байна.

Энэ онд ээлжит шударга байдлын үнэлгээний тайланг одоогийн байдлаар АТГ-аас олон нийтэд зарлаагүй байна.

3.4. Хэрэглэгчийн үнэлгээ

Үзүүлэлт	Дундаж оноо	Үнэлгээ /хувиар/	Тайлбар
1. Хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж буй шат дамжлага, шуурхай, найдвартай байдал	3.83	76.7	Хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж буй шат дамжлага, шуурхай байдлын түвшинг хурдан шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ, нэг удаагийн ирэлт, үйлчилгээний шат дамжлага, цагийн хуваарь зэрэг нийт 7 үзүүлэлтээр үнэлүүлж дундаж үнэлгээг гаргав.
2. Үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.63	72.5	Үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжтэй байдлыг мэдээллийн нээлттэй байдал, ажилчдын тоо, мэдээлэл авах суваг, байгууллагын цахим хуудас, мэдээддийн хүртээмж зэрэг 9 үзүүлэлтээр үнэлэв.
3. Ажилтан, албан хаагчдын зан харилцаа, мэдлэг ур чадварын талаарх үнэлгээ	3.83	76.7	Ажилтан албан хаагчдын ур чадвар, зан харилцаа, ёс зүйн талаарх үнэлгээг нийт 8 шалгуур үзүүлэлтээр тооцов.
4. Үйлчилгээний орчин нөхцлийн талаарх үнэлгээ	3.41	68.2	Үйлчилгээний орчны талаарх үнэлгээг байгууллагын гадна болон дотоод орчин нөхцөлтэй холбоотой 9 шалгуур үзүүлэлтээр үнэлэв.
5. Санал, өргөдөл гомдлыг шийдвэрлэж буй байдал	3.32	63.5	Консулын газарт ирсэн иргэдийн санал гомдлыг санал хүсэлт гаргах, эргэж мэдээлэх, шийдвэрлэх зэрэг 5 үнсэн үзүүлэлтээр үнэлэв.

ГХЯ-наас иргэдэд үзүүлдэг үйлчилгээ, үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхэд ГХЯ-ны хэрэглэгчийн үнэлгээг дараах 5 үзүүлэлтээр дүгнэсэн байна.

Хэрэглэгчийн үнэлгээний тайланг хавсаргав. /Хавсралт-4/

Тав. Дүгнэлт

ГХЯ-ны 2017 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг нэгтгэн авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	88.2	0.6	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	91.25		
	3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	93.6		
	4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	100		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	98.0	0.2	
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	89.8		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	96.3	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	87.7		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ			
	4. Хэрэглэгчийн үнэлгээ			
Ерөнхий үнэлгээ:			1.0	

ХЯНАСАН:

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ**

Б.БАЯРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ЗӨВЛӨХ**

Д.ЭНХТУЯА

ГУРАВДУГААР НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ЭРДЭНИЙНЧУЛУУ